



LAVAI-INTERNATIONAL JOURNAL OF EDUCATION

2022 №26, ISSN 2410-4507

Веб сайт: <https://lavai.msue.edu.mn>

Бүжгийн спортын тамирчдын хөгжим хөдөлгөөнийг нийцүүлэн гүйцэтгэх чадварыг судалсан нь

Дамдинсүрэн Батсайхан*

Монгол улс, Улаанбаатар, Монгол Улсын Боловсролын Их Сургууль,
Сургуулийн өмнөх боловсролын сургууль, Урлагийн тэнхим

*Холбоо барих зохиогч: batsaikhan@msu.edu.mn

Хүлээн авсан: 2022.5.10 Засварласан: 2022.6.28 Хэвлэлтэд авсан: 2022.7.1

Хураангуй

Монгол улс (МУ) бүжгийн спортын багийн төрлөөр дэлхийн тавцанд хүчтэй өрсөлдөгчийн нэгд зүй ёсоор тооцогддог. Тусгай зассан талбайд 16 тамирчин хөгжмийн аянд жигд цэгцтэй, хөдөлгөөнөөр бүжгийн зохиомжийн утга санааг техник ур чадварын өндөр түвшинд 06:00 минутын турш тасралтгүй 5 бүжгийн цогц зохиомжийг гүйцэтгэдэг багийн спортын өвөрмөц нэг төрөл юм. Бүжгийн спортын формэйшн /багийн/ төрөлд үндсэн дөрвөн үзүүлэлт 12 шалгуур үнэлгээнээс хөгжим хөдөлгөөний нийцэл нь монголын багийн тамирчдын хувьд хангалтгүй байгаа учраас түүнийг тодорхойлж тогтмол хянаж сайжруулах системтэй болгох зорилго дэвшүүлсэн. Баг тамирчдад шинжлэх ухааны үндэслэлтэйгээр бэлтгэлжилтийн төлөвлөлтөд хөгжим хөдөлгөөний нийцлийг Латин ча-ча бүжгийн дасгалын техникээр, ур чадварыг хөгжим сонсох, ойлгох, тооллого, хөдөлгөөнөө хөгжимд удирдах чадварын 3 түвшинд шалгаж, сургах туршилт зохион байгуулан судалгааны үр дүнг батлан гаргасан. Судалгаанд Стар багийн 33 тамирчдыг хамруулан 2021 онд 2 үе шаттайгаар зохион байгуулсан. Туршилтын үр дүнгээс хөгжим сонсох чадвар, хэмнэлийн мэдрэмж, хөгжим хөдөлгөөний нийцэл ур чадварын тоон үзүүлэлтүүдийн хоорондын статистикийн ач холбогдолтой олон хамаарлын талаарх таамаглалууд батлагдсан. Туршилтаас хөгжим хөдөлгөөний нийцлийн үнэлгээг чанар болон тоон үзүүлэлтээр хянаж, багийн ур чадварын ахицыг тодорхойлохоос гадна амжилт ахих боломж харагдаж байна.

Түлхүүр үг

Бүжгийн спорт, багийн төрөл /формэйшн/, шүүлтийн үнэлгээ



Удиртгал

Монголын бүжгийн спортын холбоо 2001 онд байгуулагдан, дэлхийн бүжгийн спортын холбооны (ДБСХ) тэмцээний дүрэм, журмын шүүлтийн дагуу тэмцээн уралдааныг зохион байгуулж эхэлсэн (Монголын бүжгийн спортын хороо, 2005, до.18). Багийн төрөлд 2010 оноос дэлхийд түвшинд хүчтэй өрсөлдөгч болж амжилтын түүхээ шинэчилсээр байна. Гэсэн хэдий ч төр засаг, спорт эрхэлсэн салбар хороо, холбооны зүгээс бүжгийн спортын тамирчдыг дэлхийн тавцанд өрсөлдөхүйц хэмжээнд бэлтгэхэд хөрөнгө санхүү болон материаллаг баазыг бэхжүүлэх, боловсон хүчнийг бодлогоор хангахад анхаарал хандуулах нь дутмаг байна. Тиймээс цаашид судалгаанд суурилсан үр дүнг тооцсон шинжлэх ухааны үндэслэлтэй бүтээлүүд, орчин үеийн техник технологи, бэлтгэлийн бааз, системтэй сургалтын хөтөлбөрийг бэлтгэн боловсруулах, орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Багийн тамирчид нь хамтран ажиллах чадварт суралцахаас гадна хувийн ур чадварт байгалиас заяасан өгөгдөл, сэтгэл зүй, бие бялдар, хөдөлгөөн, хөгжмийн авьяас чадвар, нөр их хөдөлмөр, шат дараалсан системтэй бүжгийн бэлтгэл сургуулилт, өөрийн хүсэл мөрөөдөлтэй байх маш чухал. Олон улсын тэмцээний шүүлтийн үнэлгээ 2013 оноос өмнө ерөнхий байдлаар дараагийн шатанд тэнцлээ гэдэг тэмдэглэгээ тавьдаг нь баг тамирчдын ур чадварыг бодиттой үнэлж чадахгүй байгааг шүүмжилж, гимнастик, уран гулгалт шиг нарийвчилсан үнэлгээтэй байх шаардлагатайг дурдсан (Jonas Rohleder* 2019). Бүжгийн спортын хуучин шүүлтийн тогтолцооны талаар тамирчид, дасгалжуулагчид, шүүгчид зарим тамирчдыг хэт өндөр үнэлэх, үнэлгээ хийх цаг богино, тамирчдын үнэлгээний зөрүү хэт ялгаатай гэх мэт асуудлууд байгаа талаар (Ambrož 2010) шүүмжлэлтэй хандаж ирсэн. Бүжгийн спортын хөгжлийг тогтвортой, тасралтгүй, хөгжүүлэхэд сургалт дасгалжуулалтыг нарийвчлан төлөвлөж, залуу үеийг системтэй бэлтгэх асуудал нэн тэргүүнд тавигдаж байна. МУ бүжгийн спортын багийн тамирчид олон улсын түвшний уралдаан тэмцээнд амжилт гаргахад ДБСХ-ноос батлагдсан тэмцээний дүрмийн шүүлтийг нарийвчлан судалж, тамирчдад байнгын тогтмол бэлтгэл сургуулилт хийх боломжийг бүрдүүлэх, хөгжим хөдөлгөөний нийцлийн суурь чадварыг тодорхойлох загвар шалгуур зайлшгүй хэрэгцээтэй байна (Монголын бүжгийн спортын хороо, 2009, до.10). Тиймээс бүжгийн спортын тэмцээний шүүлтийн ур чадварын хэсэг, хөгжим хөдөлгөөний нийцэл үзүүлэлтээр (World Dance Sport Federation 2013) (Table 1) тамирчдын хөгжим болон хөдөлгөөний ур чадварыг дээд шатанд хүргэх, амжилтаа ахиулах, хянан сайжруулах системтэй болгох зорилгоор, судалгааны шалгуурыг боловсруулан туршилт хийх хэрэгцээг үндэслэл болгосон (Мөнгөнхуяг, А., Жаргалсайхан, Ч, 2005).

Table 1
Detailed Criteria for Danse Sport Assessment


Ур чадварын хэсэг	
Техникийн шинж чанар (technique quality) Хөгжим хөдөлгөөний нийцэл (music and movement)	
Биеийн байрлал ба барилтууд	Хөгжмийн хугацаа /хэт хурдан, удаан гэх мэт/
Үндсэн техник ба зарчим	Хэмнэлийн хугацаа алхалттай тохирох үе /зөөлөн, хүчтэй, сунгах/

Үндсэн үйлдлүүд	Тодорхой хэмнэлийн шаардлага (ча ча бүжгийн 4 өөр тооллого)
Тусгай нэмэлтүүд	Биеийн хөдөлгөөнөөр хөгжмийн утгыг гүйцэтгэх үйлдэл

Хөгжим хөдөлгөөний нийцлийг хөгжүүлэхийн тулд тамирчдын бие физиологи, сэтгэл зүйг бэлтгэх сургалт, хөгжмийн хэмнэлт дасгалын зохиомж, хэрэглэгдэхүүн, техник материал хангамжийг цогцоор төлөвлөх шаардлагатай. Тамирчин бүрийн хөдөлгөөн, хөлийн алхалт нэг бүрчлэн хөгжмийн шинж төрх хэмнэлтэйгээ уялдан, хурд, хүч, даралт, өргөлт, цэгт байрших зэргийг нийцүүлэн илэрхийлж бүжиглэнэ. Хөгжмийн аяыг сонсож ойлгоод хөдөлгөөнөө хослуулан гүйцэтгэх нь бүжгийн спортын шүүлтэд тавигдах үндсэн стандарт болдог (Bijster 2017). Өнөөдрийг хүртэл бүжгийн спортын багийн төрөлд нарийвчилсан үзүүлэлтүүд болон шүүлтийн судалгаа МУ дутмаг байгаа нь тэмцээний үр дүнд нөлөөлж болзошгүй. Тиймээс шүүлтийг сайтар судлан найдвартай бэлтгэлжилтийн системтэй болгох нь боломж гэж харж байна (Монголын бүжгийн спортын хороо, 2011, до.25). Судалгааны үр дүнд тамирчдын хөгжмийн аянд хөдөлгөөнөө илэрхийлэх гүйцэтгэх чадвар сайжирна гэж таамагласан. Хөгжмийн шинж, хэмнэлийг задаргааг хөдөлгөөнөөр илэрхийлэн гүйцэтгэх чадвартай бүжигчний техник ур чадвар өндөр түвшинд байдаг (Батсайхан, 2009, х.29). Бүжгийн спортын тамирчид нь хөгжим хөдөлгөөний нийцлийн ач холбогдол үр нөлөөг сайтар ойлгосноор хөдөлгөөн удирдах чадвар, мэдрэмж дадал болж давтах хүсэл эрмэлзэл нэмэгдэж ачаалал даах чадварт суралцах, техник ур чадвар гүйцэтгэл, илэрхийлэл сайжирдаг. (Анужин, 2019, х.42).

Figure 1

Assessment of association of rhythmic movements in 2014-2019 years



Шүүлтийн хэсэг бүрийн хамгийн өндөр үзүүлэлт 10.000 оноогоор үнэлж, дөрвөн шалгуур тутам 8.000 дээш үнэлэгдэхэд шигшээд шатанд шалгарах боломж бүрддэг (WDSF 2015). Хөгжим хөдөлгөөний нийцлийн үнэлгээ 2017 онд 8.292 нь хамгийн сайн үзүүлэлт хэдий ч тэмцээн хоорондын үнэлгээг шинжлэхэд тогтворгүй жигд бус оролцсон нь харагдаж байна. Баг тамирчдын ур чадвар, бүжгийн бүтээл, бэлтгэлжилтийн хугацаа зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж болох ч системтэй бэлтгэлжилт, хяналт, үнэлгээ, судалгаанд суурилсан төлөвлөлт чухал болохыг харуулж байна.

Судалгааны арга зүй

Судалгаанд бүжгийн спортын 12 эрэгтэй 21 эмэгтэй тамирчдыг хамрагдсан. Дэлхий дахинд цар тахал (Covid-19)-ын нөхцөл байдлаас шалтгаалан хоёр жилийн хугацаанд багийн хамтарсан бэлтгэл хийгдээгүй боловч хосын болон

ганцаарчилсан бэлтгэлжилт тогтмол явагдсанаас тамирчдын түвшин харилцан адилгүй болсон. Иймээс бид судалгаа, ажиглалт үнэлгээ хийх шаардлагыг үндэслэл болгон тамирчдын бүжгийн суурь чадварыг дахин шинжлэн тодорхойлох, хөгжмийн мэдлэг ойлголт, мэдрэх чадварыг нь судалсан. Багийн спортын бүрэлдэхүүн байнга шинэчлэгдэж байдаг учир залуу тамирчдын ур чадварыг хөгжүүлж, багийн гүйцэтгэлийн ур чадварыг богино хугацаанд сайжруулахад судалгааны шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах хэрэгцээ байсан. 2021 оны 10-р сард бэлтгэлжилтийн төлөвлөгөөг боловсруулан тамирчдын ур чадварын түвшинг 14 хоног тутам сорилоор түвшинг тодорхойлон харьцуулалт хийж, тусгайлсан хөтөлбөрийн дагуу бэлтгэл сургалт хийсэн. Судалгааны хүрээнд нотлох болон батлах туршилтыг 2022 оны 03-р сарын 01-ээс эхлүүлэн гурван долоо хоногийн хугацаанд зохион байгуулж үр дүн тооцсон. Бид судалгаандаа шүүлтийн систем дэх хөгжим хөдөлгөөний нийцлийн дөрвөн шалгуурыг дэлгэрэнгүй авч хөгжмийн хэмнэлд Латин бүжгийн хөдөлгөөний олон хувилбарыг хэрхэн нийцүүлэн илэрхийлж, гүйцэтгэж байгааг харгалзан үзсэн. Латин бүжгийн хөгжим хөдөлгөөний нийцлийг 0-5 хүртэлх тоон болон чанарын үнэлгээгээр тооцон MS excel, SPSS25 программ ашиглан, шалгах болон баталсан үр дүнг (Paired-Samples T test) туршилтын өмнөх ба дараах гүйцэтгэх ур чадварын хамаарлыг шинжлэхэд корреляцийн шинжилгээний аргыг тус тус ашигласан болно.

Figure 2

Assessment factors for rhythmic movement associations



Судалгаанд тамирчдын хөгжмийн мэдлэг ойлголт, хэмнэл мэдрэх чадварыг хөдөлгөөнөөр илэрхийлэн гүйцэтгэхэд шалгуур үзүүлэлтийг авч үзсэн. Тамирчид хэмнэл мэдрэх 2 даалгавар, хэмнэл тоолох 1 даалгавар, хөдөлгөөнөө хөгжимд удирдах 3 даалгавар бүхий шалгуурыг шинээр боловсруулан туршилт судалгааг хийсэн. (Зураг 2). Түвшингийн үнэлгээ: 5 оноо Маш сайн, 4 оноо Сайн, 3 оноо хангалттай, 2 оноо боломжийн, 1 оноо дэмжлэг шаардлагатай.

Судалгааны үр дүн

Латин ча-ча бүжгийн дасгалын техникээр, тамирчдын ур чадварыг тодорхойлох үед хөгжим сонсож ойлгох, тооллого, хөдөлгөөнөө хөгжимд удирдах чадварын 3 түвшинд шалгуурыг шинээр боловсруулсан. Үүнээс аялгуугүй хэмнэлийн шалгуур үзүүлэлтээр нийт тамирчдын 39.4% сайн, 60.6% маш сайн үнэлэгдсэн. Аялгуутай хэмнэлийн үед 75.8% сайн, 24.2% маш сайн болж өөрчлөгдсөн. Харин бүжгийн хэмнэлийн тооллогыг шалгахад 6.1%, хангалттай, 81.8% сайн, 12.1%, маш сайн гарсан нь маш сайн үзүүлэлт багасаж, сайн түвшин нэмэгдсэн байна. Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө удирдах чадвар 1 шалгуурууд 6.1% хангалттай, 93.9% сайн үнэлгээтэй гарсан. Эндээс үзвэл үндсэн хэмнэлийг тамирчид сайн сонсож, ойлгож байгаа давуу талтай ч, хэмнэл тоолох, хөгжмийн хэмнэл хөдөлгөөнөө удирдах чадвар 1 /хөгжмийн аяны урт, богино, хүчтэй сул байдлыг биеэр илэрхийлэх/ шалгуур суларсан үзүүлэлт нь багаараа өндөр түвшинд бүжиглэхэд сөргөөр нөлөөлөх боломжтой гэж дүгнэсэн. (Table 2).

Table 2
Average assessment data

	Хөгжмийн аялгуугүй үед хэмнэл мэдрэх чадвар	Хөгжмийн аялгуутай үед хэмнэл мэдрэх чадвар	Хөгжмийн хэмнэлд дагуу бүжгийн тооллого ашиглах	Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө удирдах чадвар		
				Их биеийн болон хөлийн шилжих хөдөлгөөнүүд /bronze/	Их биеийн болон хөл, ташаан хөдөлгөөн /silver/	Их бие, хөлийн болон ташаан хөдөлгөөн цээж, нурууны хөдөлгөөн /gold/
Авах ёстой оноо	5	5	5	5	5	5
Дундаж оноо	4.61	4.24	4.06	4.06	3.27	2.58
Хувиар	92.2%	84.8%	81.2%	81.2	65.4	51.6

Туршилт судалгааны дараа тамирчдын хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө удирдах чадвар 2 даалгавар /их биеийн болон хөл, ташаан хөдөлгөөн/ дөлгөөнөө удирдах чадвар 2 даалгавар 3 /их бие, хөлийн болон ташаан хөдөлгөөн, цээж, нурууны хөдөлгөөн/ үзүүлэлтийн батлах, нотлох харьцуулсан байдлыг авч үзүүлбэл.

Table 3
Ability-2 to Manage the Movement of the Proving and Verifying Experiments

		Нотлох туршилтын үнэлгээ ба онооны дундаж		Батлах туршилтын үнэлгээ ба онооны дундаж	
Valid	Боломжийн	9.1	3.27	0	3.82
	Хангалттай	57.6		33.3	
	Сайн	30.3		51.5	
	Маш сайн	3.0		15.2	
	Total	100.0		100.0	

Дээрх хүснэгтээс харахад хөгжмийн хэмнэлт дасгалд тохируулан хөдөлгөөнөө удирдах чадвар 2 нотлох, батлах судалгааны шалгуур үзүүлэлтийг харьцуулахад нийт судалгаанд оролцсон тамирчдын маш сайн түвшинд 1 тамирчин буюу 3% байсан бол 5 тамирчин болж 15% болон өссөн. Сайн түвшинд 10 тамирчин 30.3%-аас 7 тамирчнаар нэмэгдэж 51.5%, хангалттай 19 тамирчин 57.6%-аас 11 тамирчин 33.3% болж багассан. Нотлох туршилтын боломжийн түвшинд 3 тамирчин 9.1% -аар өссөн. Тамирчны ур чадварын үнэлгээ дундаж нотлох туршилт хийхэд 3.27% байсан үнэлгээ 3.82 болж 0.55%-аар ахисан дүн гарсан.

Table 4
Ability to Manage the Movement of the Proving and Verifying Experiments /percentage/

		Нотлох туршилтын үнэлгээ ба онооны дундаж		Батлах туршилтын үнэлгээ ба онооны дундаж	
Valid	Дэмжих шаардлагатай	6.1	2.58	0	3.06
	Боломжийн	45.5		24.2	
	Хангалттай	36.4		51.5	
	Сайн	9.1		18.2	
	Маш сайн	3.0		6.1	
	Total	100		100	

Дээрх хүснэгтээс харахад хөгжмийн хэмнэлт дасгалд тохируулан хөдөлгөөнөө удирдах чадвар 3 нотлох, батлах судалгааны шалгуур үзүүлэлтийг харьцуулахад нийт судалгаанд оролцсон тамирчдын маш сайн түвшинд 1 тамирчин буюу 3.0%, байсан бол 2 тамирчин болж 6.1% болон өссөн. Сайн түвшинд 3 тамирчин 9.1%-аас 3 тамирчнаар нэмэгдэж 18.2%, хангалттай 12 тамирчин 36.4%-аас 17 тамирчин 51.5% болж багассан. Нотлох туршилтын боломжийн түвшинд 15 тамирчин 45.5% байсан бол батлах туршилтад түвшинд 8 тамирчин буюу 24.2% тамирчны ур чадвар ахисан бол дэмжлэг шаардлагатай 2 тамирчин 6.1% үзүүлэлтээс ахисан үр дүн гарсан. Тамирчны ур чадварын үнэлгээ дундаж нотлох туршилт хийхэд 2.58% байсан үнэлгээ 3.06% болж 0.55%-аар ахисан дүн гарсан.

Table 5
Comparative Analysis of the Research Data

		Дундаж	N	Стандарт хазайлт	Стандарт Алдаа	t	Sig
Шалгуур 1	Хөгжмийн аялгуугүй нотлох	4.61	33	.496	.086	- 2.390	.023
	Хөгжмийн аялгуугүй батлах	4.76	33	.435	.076		
Шалгуур 2	Хөгжмийн аялгуутай нотлох	4.24	33	.435	.076	- 4.000	.000
	Хөгжмийн аялгуутай батлах	4.58	33	.502	.087		
Шалгуур 3	Хэмнэлийн тооллого нотлох	4.06	33	.429	.075	- 3.730	.001
	Хэмнэлийн тооллого батлах	4.36	33	.549	.096		
Шалгуур 4	Хөдөлгөөнөө удирдах /bronze/ нотлох	4.06	33	.242	.042	- 2.101	.044
	Хөдөлгөөнөө удирдах /bronze/ батлах	4.18	33	.392	.068		
Шалгуур 5	Хөдөлгөөнөө удирдах /silver/ нотлох	3.27	33	.674	.117	- 4.707	.000
	Хөдөлгөөнөө удирдах /silver/ батлах	3.82	33	.683	.119		
Шалгуур 6	Хөдөлгөөнөө удирдах /gold/ нотлох	2.58	33	.867	.151	- 4.503	.000
	Хөдөлгөөнөө удирдах /gold/ батлах	3.06	33	.827	.144		

Статистикийн үр дүнд хөгжим хөдөлгөөний нийцлийн нотлох судалгааг батлах судалгааны үр дүнтэй харьцуулалт хийн “Paired Samples T Test”-ээр шинжилгээ хийсэн. Хөдөлгөөнөө удирдах шинжилгээний үр дүнд шалгуур 4-ийн дундаж утга нь 4.06-аас 4.18; стандарт хазайлт нь 0.242 байсан бол 0.392 болон 0.150 гарсан; стандарт алдаа утга нь 0.42-оос батлах туршилтаар 0.68 болон өссөн; sig=0.044 гарсан ба энэ нь 0.05 бага буюу статистикийн хувьд ач холбогдолтой гэсэн үр дүн гарсан. Үүнээс шалгуур-4 хувьд батлах судалгаа нь нотлох судалгаанаас ялгаатай буюу ур чадвар ахисан гэсэн үр дүн гарсан (Table 5). Шалгуур-5 хувьд дундаж утга нь 3.27 байсан бол 3.82 болон өсөж; нотлох туршилтаар стандарт хазайлт нь 0.674 байсан бол батлах туршилтаар 0.683 ; стандарт алдаа утга нь 0.117-0.119; sig=0.000 гарсан ба энэ нь 0.05 бага буюу статистикийн хувьд ач холбогдолтой бөгөөд батлах судалгаа нь нотлох судалгаанаас ялгаатай буюу ур чадвар ахисан үр дүн гарсан. Шалгуур-6 хувьд 2.58 дундаж утга нь 3.06 болон нэмэгдэж; стандарт хазайлт нь 0.867 - 0.827 болон буурсан; стандарт алдаа утга нь 0.155-аас 0.144; sig=0.000 гарсан ба энэ нь 0.05 бага буюу статистикийн хувьд ач холбогдолтой гэсэн үр

дүнтэй бөгөөд батлах болон нотлох судалгаанаас ялгаатай буюу ур чадвар ахисан үр дүнгүүд гарсан. Энэхүү статистик тоо баримт нь судалгааны ажлын хүрээнд дэвшүүлсэн хөгжим сонсох чадвар, хэмнэлийн мэдрэмж, хөгжим хөдөлгөөний нийцэл ур чадварын тоон үзүүлэлтүүдийн хоорондын статистикийн ач холбогдолтой хамаарлын талаарх таамаглалууд батлагдсан болно.

Хэлэлцүүлэг

Дмитрий Беляуски Беларусийн бүжгийн спортын холбоо “Бүжгийн спортын багийн бэлтгэлийн төлөвлөгөө” (Bialiausk 2018, хууд 66 – 82) эрдэм шинжилгээний өгүүлэлд цаг хугацаанд хэрхэн бэлтгэлжилтийг нарийн төлөвлөх стандарт бүжгийн багийн тэмцээн бүрийн дүнг харьцуулсан шинжилгээ хийсэн нь бидний хийсэн судалгаанд илүү нарийвчлалтай үзүүлбэрийн гол чухал хэсэг болох хөгжим сонсох ойлгох чадвар нь тамирчдын техник, багийн ур чадвар, бүтээлч илэрхийлэл дотоод сэтгэлд нөлөөлөх боломжтой гэж дүгнэсэн. “Хөгжим хөдөлгөөний нийцэл” үзүүлэлтээр 6 шалгуур боловсруулан дан ганц ча ча бүжгийн дасгал хөдөлгөөний зохиомж гадна хөгжмийн бүтцийг ойлгох, түүнийг зөв тоолох, хөдөлгөөнөө удирдах, гүйцэтгэл үр дүнд мэдэгдэхүйц сайжирсан нь судалгаа үр дүнд хүрэх боломжтой гэж үзсэн.

Роман Гриценюк (Gritsenyuk.R 2021, хууд 83-88) бүжгийн спортын багийн төрлийн бүжгийн дэг, найруулгад хос бүжгээс ялгаатай нь багаар 6 минут үргэлжилдэг бөгөөд үүнээс 4.5 минут нь үнэлгээтэй холбоотой үндсэн хэсэгт, 1.5 минут нь эхлэл, төгсгөл хугацаанд зориулагдсан байдаг. Латин Америкийн бүжгийн хосын төрлөөс ялгаатай нь бүжгийн үе шат бүрд нэг дор таван бүжгийн найруулсан зохиомжийг зогсолтгүй гүйцэтгэдэг. Хөдөлгөөний элементүүд, эрэгтэй, эмэгтэй тамирчдын үүрэг даалгавар, хөдөлгөөн ур чадвар, байрлалын онцлог шинж чанар нь илүү түгээмэл харагдавч талбайн зураглалд хамаарч хязгаарлагдмал төрхүүд буюу биеийн шугам /толгойноос хөлийн хоорондох би үргэлжилсэн зураас/ динамик /цаг хугацааны явцад хөдөлгөөнд хэрэглэх эрч хүч, хүчин чармайлт, хүч, жин/ байдаг тухай судалсан байдаг. Эндээс үзвэл бидний судалгаанд хөдөлгөөнөө удирдах чадвар 1-3 хүртэлх түвшний шалгууртай харьцуулахад тухайн тамирчин бүр бүжгийн онцлог, биеийн байрлал хадгалах чадвар, хөгжмийн ая, хэмнэл, хурд, хүч зэрэг олон хүчин зүйлийг сонсох, ойлгох чадвар ялгаатай байсныг туршилт судалгаагаар нэг хөгжмийн ойлголт, нэг хөдөлгөөн, нэгэн жигд бүжиглэхэд нөлөөлсөн гэж харж байна.

Словени, Любляна их сургуулийн спортын факультет (Jerneja Premelč et all 2019) нарын хамтарсан баг бүжгийн спортын шүүлтийг үнэлэх анхны судалгааг хийсэн бөгөөд ирээдүйд түүний бодитой байдал, хүчин төгөлдөр байдлыг сайжруулах боломжтой саналуудыг гаргаж үнэлгээд нарийвчлалтай дүн шинжилгээ хийсэн. Энэхүү судалгаа хосын төрлийн ур чадварыг шүүгч бүрийн онооны үнэлгээг харьцуулахад нь тэдний шүүлтийн байрлал, сонсох, бүжиглэх ур чадварыг харгалзах өнцөг өөр хэдий ч эрс тэс ялгаатай үнэлгээ байна гэж дүгнэжээ. МУ төлөөлөн ДАШТ оролцсон баг 2015 оны дэлхийн аваргад шүүгчдийн ахлагчид протокол буюу шүүлтийн буруутай үйлдэлд шалгалт хийхийг хүссэн хүсэлт өгч байсан билээ. ДБСХ-ны тэмцээний шүүлт сайн багийн хэт дэмжсэн, түүнчлэн тухайн улсын шүүгч өөрийн орны багт оноо өгдөг, онооны үнэлгээ нь бусад шүүгчээс хэт өндөр буюу ёс зүйн алдаа дутагдал гаргадаг байдал байсаар байна. Тиймээс шүүлтийн талаар асуудлыг сайтар судлан тэмцээний үнэлгээндээ дүн шинжилгээ хийж шүүгчийн болон өөрсдийн

зүгээс алдаа оноогоо тооцоолж цаашид алдаагаа давтахгүй байх байнга тамирчдын ур чадварын түвшинг тодорхойлоход энэ судалгаа нөлөөлөх боломжтой гэж үзэж байна.

Дүгнэлт

ДБСХ-ны дүрмийн дагуу бүжгийн тамирчдын хөгжим хөдөлгөөний нийцлийг үнэлэх 6 шалгуурыг 0-5 оноогоор тооцож, тоон болон чанарын үнэлгээг боловсруулан туршилт хийж, батлах болон нотлох үнэлгээг харьцуулж үзэхэд бүх шалгуурын хувьд $\text{sig} = \text{утга нь } 0.05$ бага буюу статистикийн хувьд ач холбогдолтой гэсэн үр дүнд хүрсэн. Тамирчдын ур чадварыг тодорхойлон гарсан үр дүнг харьцуулан батлах туршилтад тус бүр өссөн үзүүлэлттэй гарсан тул цаашид судалгааг бүжгийн спортын баг тамирчдын хөгжим сонсох, мэдрэх, хөдөлгөөнөө удирах гүйцэтгэх ур чадварт нөлөөлөх боломжтой гэж дүгнэсэн. Спортын шинжлэх ухаан ялангуяа бүжгийн спортын тамирчин бэлтгэхэд багш дасгалжуулалтын төлөвлөлт, үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах нэгэн хувилбарыг боловсруулж, туршин үр дүнг нэгтгэсэн нь цаашид тамирчдын хөгжим хөдөлгөөний нийцлийг хөгжүүлэх арга зүйг практикт хэрэгжүүлэх боломжтой болохыг тодорхойллоо. Судалгаанд боловсруулсан хөгжим хөдөлгөөний нийцлийг тодорхойлох шалгуур нь цаашид тамирчдын хувь чадвараас гадна багийн нийт тамирчдын хөгжмийн мэдлэг ижил түвшинд ахих, хөгжмийн аялгууны утга санааг илүү ойлгож мэдэрч, дотоод сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, багаар ажиллах, харилцах чадвар, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөртөө итгэлтэй, жигд цэгцтэй байх зэрэг оюун тархи, бие, сэтгэл зүрхний хувьд сайн суурь тавигдах нөхцөл бүрдэнэ гэж дүгнэж байна. Энэ судалгааг хэрэглээ болгосноор тамирчдын хөгжилд ахиц гарахад нөлөөлөөд зогсохгүй багш, дасгалжуулагч нар болон спортын шинжлэх ухаан, заах арга зүйн мэдлэг, ойлголттой болж, багш дасгалжуулагчид хөгжих нэгэн боломж бүрдэж байгаа нь харагдсан.

Талархал

Тус судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд тусалж, дэмжлэг үзүүлсэн “Оддын бүжиг” ТББ-ын дэргэдэх Стар хамтлаг, СӨБС-ийн багш, олон улсын шүүгч, доктор Л.Туяа нарт талархлаа илэрхийлье.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Анужин, Б. (2019). “Латин америк бүжгийн техникээр хамтлагийн бүжигчдийн ур чадварыг хөгжүүлэх нь.” *Дипломын ажил*. х.42. Улаанбаатар
- Батсайхан, Д. (2009). “Цэнгээнт бүжгийн сургалтын зарим асуудалд.” *Магистрын ажил*. х.29. Улаанбаатар
- Мөнгөнхуяг, А., Жаргалсайхан, Ч. 2005. “Стандартын болон Латин бүжгүүдийн техник.” *Стандартын болон Латин бүжгүүдийн техник*-Д, А.Мөнгөнхуяг ба Ч.Жаргалсайхан-ээр, х.3-77. Улаанбаатар: МБСХ
- Монголын бүжгийн спортын хороо. (2011). МБСХ-ны дүрэм журмууд http://www.dancesport.mn/files/2_00_MDSF_Statutes_2011.pdf
- Монголын бүжгийн спортын хороо. (2009). МБСХ-ны тэмцээний дүрэм. http://www.dancesport.mn/files/1_03_MDSF_temseenii_durem.pdf
- Монголын бүжгийн спортын хороо. (2005). МБСХ-ны формэйшний дүрэм http://www.dancesport.mn/files/1_04_Formation_durem.pdf
- Ховард, Г. (2012). *Цэнгээнт бүжгийн техник*. Улаанбаатар: Содпресс ХХК

- Ambrož, N. (2010). "Reliability of Judging in DanceSport." *New judging system*. World Dancesport Mag. 4, 36–40.
- Bialiausk, Dzmitry. (2018). "Planning of sport preparation of a formation team in dance sport: experience of the republic of belarus." *LASE Journal of Sport Science* 66 – 82.
- Bijster, F. (2017). "Changing the System of Judging." *SPORT Science & Practice* -, Vol. 7, №1 pp. 60.
- Gritsenyuk.R. (2021). "Formation in dance sports: technical and compositional features." *Mystetstvoznachchi zapysky* 83-88.
- Jerneja Premelč et all. (2019). "Reliability of Judging in DanceSport." *Frontiers in Psychology*. 2019.5. <https://doi.org/10.3389/fpsyg.2019.01001>
- Jonas Rohleder*, 1 and Tobias Vogt1. (2019). "Changes in Floor Exercise Characteristics in World Elite Male Gymnasts." *human kinetics* Jun; 67: 291–300.
- WDSF. (2015). *Rule/Competition/General/Judging_Systems*. 09 15. НЭВТЭРСЭН 2010-2022 ОНЫ 01 01. <https://www.worlddancesport.org/>.
- World Dance Sport Federation. (2013). "Judging System 2.0." *System 2.0 | In A Nutshell*25. Lausanne: WDSF, 02 13.

A study of the ability of dance sport athletes to perform music and movement

Batsaikhan Damdinsuren *

Department of Art, School of Preschool Education, Mongolian National of Education,
Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: batsaikhan@msue.edu.mn

Received:5/10/2022

Revised:6/28/2022

Accepted:7/1/2022

Abstract

Mongolia is a strong contender in the world dancesport contests. Dancesport team /formation/ contest is a unique kind of team sport where 16 athletes perform a set of 5 dance compositions continuously for 06:00 minutes with a well-organized movement and high level of technical skills on a specially prepared dance floor. There are 4 main indicators and 12 criteria for judging a dancesport formation. As our team's athletes do not have enough musical movement, we have set a goal to have a training system that identifies and constantly monitors it. In the planning of training for athletes on a scientific basis, the results of the study were confirmed by conducting experiments to test the compatibility of music and movement with Latin Cha-Cha dance exercises and to teach and train the skills of listening to and understanding of the music. The study was conducted in 2021 in two phases involving 33 athletes of the Star formation team.

Keywords

Dance sport, dance sport team (formation), judging, dance sport athletes



LAVAI-INTERNATIONAL JOURNAL OF EDUCATION

2022 №26, ISSN 2410-4507

Веб сайт: <https://lavai.msue.edu.mn>

ЗОХИОГЧ НАРТ ӨГӨХ ЗААВАР

Овог1 Нэр1, Овог2 Нэр2*

1Ажлын газрын нэрс бүтнээр

2Ажлын газрын нэрс бүтнээр

*Холбоо барих зохиогч: email@msue.edu.mn

Хүлээн авсан: 2022. .

Засварласан: 2022. .

Хэвлэлтэд авсан 2022. .

Хураангуй

Зохиогч нар гар бичвэрээ бэлдэхээс өмнө энэхүү зааврыг уншиж өөрсдийн ажлыг сэтгүүлийн шаардлагад нийцүүлэх шаардлагатай.

Илгээж буй гар бичвэрүүд нь монгол хэл дээр (хураангуйн англи хувилбартай) байх ба гар бичвэрүүд нь Бүтээлийн нэр, Хураангуй, Түлхүүр үг, Удиртгал, Судалгааны арга зүй, Үр дүн, Хэлэлцүүлэг (зарим тохиолдолд Үр дүн ба Хэлэлцүүлэг), Дүгнэлт, Талархал, Ашигласан бүтээлийн жагсаалт гэсэн дараалалтай байна.

Эрдэм шинжилгээний бүтээл нь агуулгын хувьд тухайн сэдвийн хүрээнд шинэлэг, импакт факторын үзүүлэлт бүхий сэтгүүлийн эрдэмтэн, судлаачдын бүтээлээс иш татаж, шинжилгээний тодорхой аргачлалыг хэрэглэсэн, судалгаа нь туршилт судалгаанд суурилсан, сэдвийн хүрээнд шинэлэг санааг дэвшүүлсэн, түүнийг судалгааны ажлын үр дүнгээр баталсан, ач холбогдол бүхий судалгаа байна. Мөн Лавай: Эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдэх материал нь бусад эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдээгүй байх.

Түлхүүр үг

Түлхүүр үг1, Түлхүүр үг2, гэх мэт

Удиртгал

Техник шаардлага

- Гар бичвэр нь 297x210мм (A4) хэмжээтэй 10-15 хуудсанд багтсан байна.
- Бүтээлийг Microsoft Office Word программыг ашиглан Times New Roman фонт, 11 pt үсгийн өндрийг сонгон бичнэ.
- Бүтээлийг A4 хэмжээний цаасан дээр хуудасны дээд, доод талаас 3 см, баруун, зүүн талаас 2,5 см зайг үлдээж header, footer, командыг ашиглахгүй бичнэ.
- Хуудасны дугаарыг доод хэсгийг төвд зөв дарааллаар бичнэ. Гар бичвэрийн мөрний дугаар ашиглан бичнэ. Мин, сек, км, мм, см зэрэг товчлолуудыг тайлбаргүй ашиглана. Огноог жил, сар, өдөр (Ж.нь: 2022 оны 6-р сарын 17) гэсэн дарааллаар, 24 цагийн хэлбэрийг ашиглана (Ж.нь: 08:00, 17:40).
- Хүснэгт болон зураг нь бүтээлд орсон дарааллаараа дугаарлагдана. Хүснэгт болон зургийн гарчиг нь Times New Roman фонд дээр 11 pt үсгийн өндөртэйгөөр баруун талдаа зэрэгцэнэ. Бүх хүснэгт болон зургууд бичвэрт дарааллын дагуу заавал эшлэгдсэн байх ёстой. Хүснэгт болон график доторх текстийн үсгийн өндөр Times New Roman фонд дээр 10 pt байна. Хүснэгтийн нэмэлт тайлбарыг доод талд нь адил фонд, үсгийн өндөр өндөр ашиглан бичнэ. Хүснэгт, графикийн дугаар болон нэрийг англи хэлээр бичнэ. Жишээ:



This article is published under the
Creative Commons CC-BY License by 4.0


©2022 Author(s)

Table 1
Mathematics course content

№	Судлагдахуун	ББМД1 хичээлээр хасагдсан агуулга /1951-2016/
1	Ерөнхий заах арга	2 ангитай зэрэг ажиллах хичээлийн төлөвлөгөө Сурагчдын дэвтрийн ажиллагаа бичгийн ажлыг явуулах ба шалгах
2	Тоо тоолол заах арга	Сампин дээр нэмэх, хасах
3	Алгебрын материал заах арга	Хийсвэр тооны томъёо зохиож бодлого бодох
4	Геометр заах арга	Газар дээр шулуун байгуулах ба түүнийг хэмжих

1 Бага боловсролын математикийн дидактик

Figure 1
Experiment result



Эшлэл авах шаардлага

Эшлэл, ном зүйг АРА загвараар бичиж гүйцэтгэсэн байна.

а) Бүтээлийн дунд эшлэл

“Тогтворшилтой хөгжлийн төлөөх боловсролын хамгийн гол шинж нь амьдралын туршдаа суралцах чадвар (Жадамбаа 2015а), бүхэллэг байдал ба хичээл хоорондын харилцан хамаарал зэргийг болон бүтээлч эрэл хайгуул, эргэцүүлэх сэтгэлгээ (Жадамбаа 2015с), тогтолцооны сэтгэлгээ, асуудал шийдвэрлэхүйд түшиглэх зэргийг онцгойлон дэмждэг явдал” (Жадамбаа 2015b, х.5).

б) Шууд эшлэл / Зохиогчийн бичсэн агуулгыг өөрчлөлгүйгээр шууд эшлэх/

1. Нэг зохиогчтой бүтээлээс эшлэл авах

“Эшлэл” (зохиогчийн нэр, он, хуудасны дугаар).

“Багш өөрийн үйл ажиллагааны хамгийн бэрхшээлтэй багш, сурагч, хичээлтэй уялдаатай тодорхой асуудлыг сонгох хэрэгтэй” (Батхуяг, 2018, х.5).

Зохиогч нь тодорхойгүй тохиолдолд эрхлэн гаргасан байгууллагын нэрийг бичнэ

“Эшлэл” (Байгууллагын нэр, он, хуудасны дугаар).

“Хоол тэжээлийн талаарх хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангаж, өвчнийг бууруулахад оршино” (Монгол улсын засгийн газар, 2015, х.2).

Хоёр зохиогчтой бүтээлээс эшлэл авах

“Эшлэл” (зохиогчийн нэр & зохиогчийн нэр, он, хуудасны дугаар).

“Багш өөрийн үйл ажиллагааны хамгийн бэрхшээлтэй багш, сурагч, хичээлтэй уялдаатай тодорхой асуудлыг сонгох хэрэгтэй” (Батхуяг & Бурмаа, 2018, х.5).

Зохиогчийн нэр & зохиогчийн нэр (он), “Эшлэл”.

Батхуяг & Бурмаа (2010), Багш өөрийн үйл ажиллагааны хамгийн бэрхшээлтэй багш, сурагч, хичээлтэй уялдаатай тодорхой асуудлыг сонгох хэрэгтэй”.

Гурав ба түүнээс дээш зохиогчтой бүтээлээс эшлэл авах

“Эшлэл” (зохиогчийн нэр, зохиогчийн нэр, зохиогчийн нэр, он, хуудасны дугаар).

“Тогтворшилтой хөгжлийн төлөөх боловсролын хамгийн гол шинж нь амьдралын туршдаа суралцах чадвар, бүхэллэг байдал ба хичээл хоорондын харилцан хамаарал зэргийг дэмждэг явдал” (Жадамбаа нар, 2015, х.5).

с) **Шууд бус эшлэл** /Зохиогчийн санааг утгыг нь алдагдуулахгүйгээр өөрийн үгээр тайлбарлан утгачилж эшлэх/

Боловсролын төсөв нь боловсролын үйлчилгээг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл бөгөөд боловсролын чанарт нөлөөлдөг чухал хүчин зүйлүүдийн нэг юм. Боловсролын үйлчилгээг нийтэд хүргэхийн тулд төсвийн бүрдүүлэлтийн баталгаатай байдлаас гадна бас төсвийн хуваарилалт чухал байдаг (Kong Chun, 1989, х.33).

д) **Дам эшлэл** /Зохиогчийн санааг бусдын эшилснээс авч эшлэх/

Равжаагийн цаасан шувуу сургаалд, багшийн эрдэм мэдлэг хэдий их биш ч уян зөөлөн, сэтгэл гаргагч бол шавд эрдмийг харамгүй заахыг сургасан нь эрдэм заагч багшид сэтгэл байхад эрдмийг зааж болно хэмээжээ (Ганхуягийн эшилснээс, 2011, х.6).

Ном зүй бичих шаардлага

Ном зүйн жагсаалтыг эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудын хавсралтын өмнө оруулна. Ном зүй нь тухайн судалгаа, боловсруулалтын ажил ямар чиглэл хүрээний, хэдий хэмжээний эх сурвалж, баримт хэрэглэснийг илэрхийлэн харуулдаг төдийгүй тухайн бүтээлийг уншиж танилцаж байгаа хүнд эх сурвалжийг магадлах эсвэл цааш сонирхон судлах замыг нээж өгдөг мэдээллийн чухал хэрэгсэл юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт формат

Судалгааны ажлын ном зүйн нэршлийг Times New Roman, 11pt, тод (Bold)-оор, хуудасны зүүн гар талд “Ашигласан бүтээлийн жагсаалт” гэсэн үгийг догол мөргүй, эрдэм шинжилгээний өгүүллийн ном зүйн нэршлийг Times New Roman, 11pt, эхний үсгийг томоор, тод (Bold)-оор зүүн гар талд “Ашигласан бүтээлийн жагсаалт” гэсэн үгийг догол мөргүй тус тус бичнэ. Үүний араас ном зүйн жагсаалтыг нэг мөр алгасаж, эх сурвалжуудыг дугаарлахгүй, зохиогчийн нэрийг мөрийн эхнээс бичиж, дараагийн мөрүүдийг догол мөрнөөс, зохиогчийн нэрийг харахад хялбар байдлаар бичнэ. Мөн мөр хоорондын зай (Spacing: After 0pt, Before 0pt) байна.

НОМ/BOOK

Нэг зохиогчтой ном/ book

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар.

Lastname, F. M. (Published year). *Book title*. City, State: Publisher.

Хоёр зохиогчтой ном/book

Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар.

Lastname, F. M., Lastname, F. M. (Published year). *Book title*. City, State: Publisher.

Гурваас таван зохиогчтой ном/book

Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар.

Lastname, F. M., Lastname, F. M., Lastname, F. M. (Published year). *Book title*. City, State: Publisher.

Зургаагаас дээш зохиогчтой ном/book

Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., Зохиогч, овгийн эхний үсэг томоор., бусад. (хэвлэсэн он). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар.

Lastname, F. M., Lastname, F. M., Lastname, F. M., Lastname, F. M., Lastname, F. M., Lastname, F. M. et al. (Published year). *Book title*. City, State: Publisher.

Нэг зохиогчтой хэд хэдэн ном/book

Нэг зохиогчтой хэд хэдэн эх сурвалжийг ном зүйд бичилт хийхдээ хэвлэсэн он дарааллаар байршуулна.

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он /2000). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он /2005). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар

Lastname, F. M. (year/2000). *Book title*. City, State: Publisher.

Lastname, F. M. (year/2005). *Book title*. City, State: Publisher.

Нэг зохиогчтой нэг онд хэвлэгдсэн хэд хэдэн бүтээл/book

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он /2000). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он /2000 а). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он 2000 b). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар

Lastname, F. M. (year/2000). *Book title*. City, State: Publisher.

Lastname, F. M. (year/2000a). *Book title*. City, State: Publisher.

Lastname, F. M. (year/2000b). *Book title*. City, State: Publisher.

Байгууллагаас эрхлэн гаргасан бүтээл/book

Байгууллагын бүтэн нэр. (хэвлэсэн он). *Бүтээлийн нэр*. (дугаар). Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар.

Organization name(s). (Published year). *Book title*. Location: Publisher.

Нэг зохиогчтой ном/ book-DOI

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар. doi:xx.xxxxxxxx

Lastname, F. M. (Published year). *Book title*. City, State: Publisher. doi:xx.xxxxxxxx

Тайлбар толь, номын бүлэг/ reference book, book chapter-DOI

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). Номын бүлгийн нэр. Редакторын нэр. Овгийн эхний үсэг. (ред). *Бүтээлийн нэр*. Хэвлэсэн хот: Хэвлэлийн газар. doi:xx.xxxxxxxx

Lastname, F. M. (Published year). Title of chapter or entry. A.Editor (ed), *Book title*. City, State: Publisher. doi:xx.xxxxxxxx

СЭТГҮҮЛ /JOURNAL

Хэвлэмэл сэтгүүл

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он /2000/). Өгүүллийн нэр. *Сэтгүүлийн нэр*, дугаар, хуудасны дугаарууд.

Lastname, F. M. (Published year). Article title. *Journal Title, Volume(Issue), Page(s)*.

Хэвлэмэл сэтгүүл /DOI/-7 болон түүнээс дээш

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он /2000/). Өгүүллийн нэр. *Сэтгүүлийн нэр*, дугаар, хуудасны дугаарууд. doi:xx.xxxxxxxx

Lastname, F. M. (Published year). Article title. *Journal Title, Volume(Issue), Page(s)*. doi:xx.xxxxxxxx

Сонин/Newspaper

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он, сар, өдөр). Өгүүллийн нэр. *Сонины нэр*, дугаар, хуудасны дугаарууд.

Lastname, F. M. (Year, Month Day published). Article title. *Newspaper Title, Page(s)*.

Патент/Patent

Зохиогч, овгийн эхний үсэг томоор. (хэвлэсэн он). *Патент олгосон улсын нэр дугаар*. Retrieved from <https://www.someaddress.com/full/url/>

Lastname, F. M. (Published year). Patent number. Retrieved from <https://www.someaddress.com/full/url/>

Хууль эрх зүйн баримт/Legislative materials

Эрх зүйн баримтын нэр батлагдсан он (Баталсан байгууллагын нэрийн товчлол/УИХ) (Байршил).

Short name act year. (Jurisdiction abbreviation). (Country abbreviation)

Тушаал

Тушаалын нэр/ дугаар, байгууллагын нэр (он)

Title/ number, volume source xxx (year)

Тогтоол

Тогтоолын нэр. No. хуудасны дугаар (он)

Exec. Order No. xxxxx page (year)

Жич: Цахим хуудас, сурах бичгээс эшлэл авахыг хориглоно.

Дүгнэлт

Өгүүлэлд гарсан үр дүнг логик уялдаатай дүгнэнэ. Гаргалгаа байхгүй дүгнэлт оруулахгүй.

Талархал

Өгүүлэл бичихэд шууд хамааралтай этгээдэд, шүүмжлэгч нарт талархал илэрхийлнэ.

Ном зүй

Ijaduola, K.O., Odunaike, K.O., & Ajayi, V.B. (2012). The interplay between politics and education in Nigeria: any symbiotic relation? *Journal of Education and Practice* 3(9), 123-130.

Kasuga, W. (2019). The influence of politics in curriculum change and innovation in Tanzania. *European Journal of Education Studies* 12(5). <https://doi.org/10.5281/zenodo.25959554>

English Title Here

Firstname1 Lastname1, Firstname2 Lastname2*

1Address

2Address

* Corresponding author:: email@msue.edu.mn

Received: / /2022

Revised: / /2022

Accepted: / /2022

Abstract

An abstract is a short summary of your (published or unpublished) research paper, usually about a paragraph (c. 6-7 sentences, 150-250 words) long. A well-written abstract serves multiple purposes:

- an abstract lets readers get the gist or essence of your paper or article quickly, in order to decide whether to read the full paper;
- an abstract prepares readers to follow the detailed information, analyses, and arguments in your full paper;
- and, later, an abstract helps readers remember key points from your paper.

It's also worth remembering that search engines and bibliographic databases use abstracts, as well as the title, to identify key terms for indexing your published paper. So what you include in your abstract and in your title are crucial for helping other researchers find your paper or article.

Keywords

Keyword1, Keyword2, etc.